

Сургуулийн өмнөх боловсролын бодлогын хэрэгжилт, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Батбаяр Энхсайхан

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх							
1	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Байгууллагын тоо, хэрэгжилтийн хувь, тайлан, зөвлөмжийн тоо	2024 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, тайлан	Сургалтын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.	Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны А/50, А/84 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын 5 цэцэрлэг, нийслэлийн Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 4 сургууль, 10 цэцэрлэгийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан сургуулийн өмнөх боловсролын 15	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгууллага, ерөнхий боловсролын 4 сургуулийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг, удирдлагын гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилттэй танилцахад, ерөнхий боловсролын сургуулиуд нь сургуулийн дүрмийг боловсруулахдаа БШУ-ы сайдын 2024 оны А/100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “ЕБС-ийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.4; 1.5; 1.6-д заасныг бүрэн хэрэгжүүлж боловсруулаагүй, мөн дүрмийн 7.1-д “Сургуулийн дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ” заасныг хэрэгжүүлээгүй, мөн СӨБ-ын байгууллагууд нь БШУ-ы сайдын 2023 оны А/569 тушаалаар баталсан “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.2-д заасныг баримтлаагүй, өөрийн		
--	--	--	--	--	--	--	--

					үйл ажиллагааны онцлогийг тусгалгүй үлгэрчилсэн дүрмийг шууд хуулбарлан улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн зөрчил илэрсэн. Сургалтын байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамтай танилцахад, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.2 дахь заалтыг дотоод журамд тодорхой тусгасан байна. Байгууллагын удирдлагын гаргасан тушаал шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлангийн боловсруулалтад шинжилгээ хийж, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 214 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Баримт бичгийн бүрдэл MNS 5140-2:2021 стандарт, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар		
--	--	--	--	--	---	--	--

					батлагдсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг мөрдөж ажиллах, нэгж байгууллага бүр дээр гарсан алдаа, дутагдлыг арилгуулах чиглэлээр зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Хавсралт: 2 файл		
2	Харьяа байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах	Сургалтын тоо, оролцогчдын тоо, хэрэгжилтийн хувь	Сургалтын тоо 2 Оролцогчдын тоо 120	Аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргүүдийн Боловсролын хэлтсийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна.	Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын хорооны санаачилга, аймгийн Засаг даргын дэмжлэгээр 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, эмч нарт “Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хоол үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх” захиалгат сургалтаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 51	5-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ажилтанд хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын үр дүнгийн талаар сургалт зохион байгуулсан. Хавсралт: 1 файл		
3.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг үнэлүүлэх							
3	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Гүйцэтгэлийн чанар, үр дүн	2024 онд 5 зорилтын хүрээнд 9 арга хэмжээ төлөвлөж 96,7 хувьтай хэрэгжсэн.	Заасан хугацаанд хэрэгжилтийг бодитой тайлагнана.	ТАХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хагас жилийн байдлаар тайлагнаж, тухайн сар бүрийн холбогдох тайлан мэдээг гаргаж ажилласан. Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийн жагсаалтыг батлахаар заасны дагуу урьдчилсан байдлаар цэцэрлэгийн хүүхдийн хичээлийн хэрэглэл, эрүүл ахуйн хэрэгслийн жагсаалтаар зах зээлийн үнийн судалгааг гаргаж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					тооцоолохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
3.2. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллаж, байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангана.							
4	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах албан бичгийг шийдвэрлэх, ажлын тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэн өгөхөд бэлтгэх	Шийдвэрлэсэн албан бичгийн тоо, хувь Тайлангийн тоо	2024 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ 5 ажлын тайлан нэгтгэн боловсруулж, 13 албан бичгийг шийдвэрлэсэн.	2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны баримт материалыг архивт хүлээлгэж өгөхөд бэлтгэнэ. Ажлын чиг үүргийн дагуу ирсэн албан бичгийг танилцуулж шийдвэрлэнэ.	1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын нэгтгэсэн 4 тайлан, холбогдох материалуудын хамт 2 хадгаламжийн нэгж бүрдүүлж, хүлээлгэн өгч ажиллалаа. 2. Хариуцсан чиг үүргийн хүрээнд ирсэн 2 албан бичгийг хүлээн авч 1 бичгийг шийдвэрлэсэн, 1 албан бичиг судлагдаж байгаа, 12 албан бичиг боловсруулж харьяа байгууллагуудад хүргүүлсэн. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх	Хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо Шийдвэрлэлтийн хувь	2024 онд иргэдээс ирүүлсэн 15 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	1. БЕГ-т хандаж Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын цэцэрлэгийн хамт олноос ирүүлсэн өргөдөлд Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг баримтлан дэлгэрэнгүй мэдээлэл,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

					тайлбарыг утсаар өгч шийдвэрлэсэн. 2. Нийслэлийн ерөнхий боловсролын 6 дугаар сургууль, 34 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдлийг хянаж үзээд, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн БЕГ-ын даргын 2025 оны 1/316, 1/339 дугаартай албан бичгээр эрхлэх асуудлын бүрэн эрх, чиг үүргийн дагуу нийслэлийн Боловсролын газарт шилжүүлж ажилласан. 3. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс ирүүлсэн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 3-р сургуулийн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийг судалж танилцаад, тус сургуулийн захирлаас мэдээлэл, тайлбар авч иргэнд утсаар хариу өгсөн. Гомдол гаргасан	12-р сар	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	----------	--

					иргэний саналыг Дорноговь аймгийн Боловсролын газрын мэргэжилтэнд мэдэгдэж, орон нутгийн хэмжээнд холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар чиглэл өгч ажиллалаа. 4. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс НБГ-ын зарим мэргэжилтэнтэй холбоотой ирүүлсэн 2 өргөдлийг чиг үүргийн дагуу НБГ-т албан бичгээр шилжүүлсэн. 5. БЕГ-т хандаж иргэнээс ирүүлсэн гомдолтой танилцаж, Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.15-д зааснаар БС-ын 2024 оны А/175 тушаалаар батлагдсан журмын дагуу сургуулийн удирдлагыг шилжүүлэн ажиллуулах асуудлыг чиг үүргийн хүрээнд НБГ хэрэгжүүлэх тул иргэнд утсаар тайлбар мэдээлэл өгч шийдвэрлэлээ. 6. БЕГ-т хандаж 3 иргэнээс ирүүлсэн гомдлыг хянан үзээд, сургалтын		
--	--	--	--	--	---	--	--

					байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зэрэг асуудал нь боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэгт хамаарч байсан тул харьяаллын дагуу Завхан аймгийн болон нийслэлийн Боловсролын газарт шилжүүлж, иргэнд утсаар тайлбар мэдээлэл өгч ажилласан. Хавсралт: 2 файл		
6	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	ХАСХОМ, хуулийн хэрэгжилт	ХАСХОМ хугацаанд хүргүүлсэн.	Мэдүүлгийг заасан хугацаанд хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хугацаанд мэдүүлсэн. ХАСХОМ-ийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр системд оруулж баталгаажуулсан. Хавсралт: 1 файл	1-р сар, 6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

7	Удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу нэгдсэн мэдээ, мэдээлэл, тайланг бэлтгэн танилцуулах	Хэрэгжилтийн хувь, хугацаа, чанар	2024 онд өгсөн үүрэг чиглэлийн дагуу 5 мэдээлэл, тайланг бэлтгэн танилцуулсан.	Удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тухай бүр нэгдсэн мэдээ, мэдээлэл, тайланг бэлтгэн танилцуулна.	1. БЯ-ны ХШУДАГ-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу БШУ-ы сайдын 2022 оны А/224 тушаалын хавсралтаар баталсан журмыг үндэслэн СӨБ-ын хувилбарт сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах хяналтын хуудсыг үндсэн 15 үзүүлэлтийн хүрээнд 58 асуулгаар боловсруулж цахимаар хүргүүллээ. 2. БЕГ-ын даргын 2025 оны А/31 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын "Цонжин кибер" сургуулийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан, дүгнэлтийг гаргаж, холбогдох арга хэмжээг авч ажиллах чиглэлээр Төв аймгийн Боловсролын газар болон тус сургуульд албан бичгээр хугацаатай үүрэг өгч хүргүүллээ.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	---	-----------------------------------	--	--	---	--	---

					Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	------------------	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдана.	Үр дүн	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдсан. /3 сарын/	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна.	1. Боловсролын яамнаас зохион байгуулсан "Боловсролын салбарын өгөгдлийг үүсгэх, нэгтгэх, шинжлэх, өгөгдлийн шинжилгээг хэрэглэх, хүний нөөцийг чадавхжуулах" чиглэлийн сургалтад 2025.04.16-ны өдөр хамрагдаж, их өгөгдлийн экосистемийн талаар мэдээлэл авч ажилласан. 2. Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл" сургалтад хамрагдсан. Хавсралт: 1 файл	2-р сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх	Монгол бичгийн мэдлэгээ	Анхан шатны сургалтад хамрагдсан.	Монгол бичгийн мэдлэгээ	Монгол бичгийн мэдлэгээ сайжруулахын тулд монгол бичгийн номыг бие даан судалж,	3-р сар, 6-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ: 100%

		дээшлүүлэх, бие даан суралцах		ахиулах	унших, бичих чадвараа нэмэгдүүлж байна. Хавсралт: 1 файл	12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100%
--	--	-------------------------------------	--	---------	--	----------	------------------------------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургуулийн өмнөх боловсролын бодлогын хэрэгжилт, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Батбаяр Энхсайхан /...../ Огноо: